



АРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 10 сарын 02 өдөр

Дугаар 1135

Эрдэнэбулган сум

Аяныг эрчимжүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн “Эерэг хандлага-эмчилгээний эхлэл” аян зохион байгуулах тухай А/408 тоот тушаалын хэрэгжилтийг хангах, тус аяны хүрээнд Эрүүл мэндийн байгууллагуудын зохион байгуулж буй үйл ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагууд эмч, ажилчдын харилцаа хандлага, ёс зүйг дээшлүүлэх, байгууллагын соёлыг сайжруулах чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулж, тушаалын хэрэгжилтийг ханган ажилласугай.

2. “Эерэг хандлага-эмчилгээний эхлэл” аяныг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн үйл ажиллагааны эхний 1 сарын тайланг 2020 оны 10 дугаар сарын 05-ны дотор Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэст цахим /rujee770728@gmail.com/ хаягаар ирүүлсүгэй.

3. Тайланг хугацаанд нь авч, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга /Н.Пүрэвдулам/-д даалгасугай.

ДАРГА



Р.ГАНДИЙМАА

6512000473